

ХЭМЖИХ ХЭРЭГСЭЛД ШАЛГАЛТ БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙХ ГЭРЭЭ

№ 05/23/189

2023/15

2023 оны 02 сарын өдөр

Улаанбаатар хот

2023 оны 03 сарын 10

Энэхүү гэрээг (цаашид “гэрээ” гэх) -ийг нэг талаас “Амгалан дулааны станц” төрийн өмчит хувьцаат компани /ТӨХК/ (цаашид “захиалагч” гэх) -ыг төлөөлж Гүйцэтгэх захирал М.Мөнхөө Нөгөө талаас “Монгол-Оросын Хувь Нийлүүлсэн нийгэмлэг Улаанбаатар төмөр зам” (цаашид “гүйцэтгэгч” гэх)- ийг төлөөлж, 2023 оны 01 -р сарын 06 -ны өдрийн 10/40 тоот замын даргын итгэмжлэлээр УБТЗ-ын Хэмжил зүйн төвийн дарга Д.Түвшинбаяр (цаашид хамтад нь “талууд” гэх) нар дараах нөхцөлийг харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хэмжил зүйн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 болон 8.2.2 заалт, 10 дугаар зүйл, 22 дугаар зүйлийн 1.4 дэх заалтуудыг хэрэгжүүлэхэд захиалагчийн хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтын үйл ажиллагааны нөхцөлийг бүрдүүлэн гүйцэтгэж, буруу хэмжлийн сөрөг үр дагавраас үйлчлүүлэгч, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалахад энэхүү гэрээний зорилго оршино.

1.2. Гүйцэтгэгч, захиалагчийн хүлээх эрх, үүрэг, хариуцлага, хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтын ажлын зохион байгуулалт нь Стандарт, хэмжил зүйн газрын “Хэмжих хэрэгсэлд баталгаажуулалт хийх журам, зохион байгуулалт”-ын журмын шаардлагад нийцсэн байна.

Хоёр. Захиалагчийн эрх, хүлээх үүрэг

2.1. Хэмжил зүйн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5-д заасан үйл ажиллагаанд хэрэглэх хэмжих хэрэгслийг баталгаажуулалт хоорондын хугацаанд дээрх хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д заасны дагуу анхдагч болон ээлжит баталгаажуулалтад заавал хамруулах.

2.2. Хэмжил зүйн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.9-д заасны дагуу хэмжих хэрэгсэлд ээлжит шалгалт баталгаажуулалт хийхтэй холбогдон гарсан зардлыг захиалагч бүрэн хариуцна.

2.3. Баталгаажуулалт хоорондын хугацаа дуусахаас өмнө ээлжит бус шалгалт баталгаажуулалт хийлгэх шаардлагатай бол гүйцэтгэгчид албан ёсоор хандаж, мөн үүнтэй холбогдон гарсан гүйцэтгэгчийн бүх зардлыг хариуцна.

2.4. Эвдэрсэн буюу буруу ажиллагаатай хэмжих хэрэгслийн засварын ажлыг ээлжит баталгаажуулалт хийлгэхээс өмнө хэмжих хэрэгслийг засварлах эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллагаар гүйцэтгүүлсэн байна.

Гурав. Гүйцэтгэгчийн эрх, хүлээх үүрэг

3.1. Хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтын ажлыг эрх бүхий хэмжүүрийн улсын шалгагч, шалгалт тохируулгын ажилтан шалгах аргын үндэсний стандарт, аргачлалын дагуу хийж гүйцэтгэнэ.

3.2. Хэмжих хэрэгслийн анхдагч болон ээлжит шалгалт баталгаажуулалт гүйцэтгэхдээ улсын баталгаатай ажлын эталон хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ашиглана.

3.3. Хэрэв тухайн хэмжих хэрэгсэл нь засвар тохируулга авах боломжгүй бөгөөд стандартын шаардлага хангахгүй бол хэрэглээнээс хасах “Мэдэгдэл” олгоно.

3.4. Хэрвээ гүйцэтгэгч хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын хугацааг дуусахаас өмнө баталгаажуулалт хийх боломжгүй тохиолдолд захиалагчид албан ёсоор мэдэгдэнэ.

Дөрөв. Ажил үйлчилгээний төлбөр, тооцооны талаар

4.1. Энэхүү гэрээний хавсралтад заасан хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтын төлбөрийг “Хэмжил зүйн ажил үйлчилгээний төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай” Монгол улсын Шадар сайдын 2015 оны 11 сарын 06-ны өдрийн 117 дугаар тушаал болон “УБТЗ” ХНН-ийн даргын 2003 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А-101 тоот тушаалыг тус тус үндэслэн тооцож төлнө. Төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоосон бол сүүлийн хүчин төгөлдөр шийдвэрийг мөрдөнө.

- Вагон жингийн баталгаажуулалт (динамик) -460000 төгрөг
- Явуулын машин лаборатори шалгах аргаар (60т-с дээш) -410000 төгрөг
- Вагон жингийн баталгаажуулалт (статик) -370000 төгрөг
- Шалгах эталон вагоноор тохируулга хийхэд -270000 төгрөг
- Шалгах вагоны нэг цагийн ажлын хөлс -15000 төгрөг
- Гүйцэтгэгчийн унааны зардал - ажил гүйцэтгэх хүний тоогоор тасалгаат вагоны тарифаар тооцон очих, буцах чиглэлээр нэхэмжлэхээр төлнө.

4.2. Жин, хэмжүүрийн шалгагчийн томилолтоор явах хугацааны амрах байр, хоолны зардлыг захиалагч тал бүрэн хариуцна.

4.3. Хэмжих хэрэгсэлд ээлжит болон захиалгат шалгалт баталгаажуулалт хийсэн ажлын үр дүнг хүлээн авч, акт үйлдэж хоёр тал гарын үсэг зурсны дараа, гүйцэтгэгч төлбөрийн нэхэмжлэх өгнө.

4.4. Лаборатори вагон, Эталон вагоныг тээвэрлэх, таталт тавилтын сэлгээний ажлын зардлыг тухайн өртөөний батлагдсан үнэ тарифаар тооцож төлбөрийг бүрэн барагдуулна.

4.5. Хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтын болон холбогдох бусад зардлын төлбөрийг акт, нэхэмжлэхийг үндэслэн 14 хоногийн дотор захиалагч тал гүйцэтгэгч талын Худалдаа хөгжлийн банкны (УБТЗ-ын Хэмжил зүйн төв)-ийн 405101656 тоот дансанд шилжүүлнэ.

4.6. Гэрээний хавсралт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.

Тав. Гэрээний үйлчлэх хугацаа, гэрээ дүгнэх

5.1. Энэхүү гэрээнд талууд гарын үсэг зурж, баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд гэрээ нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал 1 (нэг) жилийн хугацаанд хүчинтэй байна.

5.2. Талууд гэрээний хэрэгжилтийг жил болгон гэрээний хавсралт, актын дагуу дүгнэж, гэрээ дүгнэсэн актыг үйлдэнэ.

5.3. Гэрээний хугацаа дуусгавар болсны дараа захиалагч нь гэрээний гүйцэтгэлийн нэгдсэн тайланг шинэ гэрээний хамт гүйцэтгэгчид албан ёсоор ирүүлж талууд гэрээний хэрэгжилтийг хамтран дүгнэнэ.

Зургаа. Бусад зүйл

6.1. Энэхүү гэрээтэй холбоотой аливаа асуудлыг Монгол улсын холбогдох хууль тогтоомж, стандарт, дүрмээр зохицуулж тайлбарлана.

6.2. Энэхүү гэрээтэй холбогдон үүсэж болох санал, маргааныг хэлэлцээрийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд талууд харилцан зөвшилцөлд хүрч

чадаагүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

6.3. Энэхүү гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг талууд албан бичгээр үйлдэж ажлын 14 хоногийн өмнө нөгөө талд мэдэгдэнэ.

6.4. Талууд гэрээг хоёр хувь үйлдэж, гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажсанаар хүчин төгөлдөр болно.

Гэрээ байгуулсан:

Захиалагчийн хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1, "Амгалан дулааны станц" ТӨХК

Харилцах Утас: 75111252, 77111253

Регистрийн дугаар: 6021646

Цахим шуудангийн хаяг:

Amgalan@amgalanplant.mn

Цахим хаяг: www.ahp.energy.mn

Гүйцэтгэгчийн хаяг: Монгол-Оросын Хувь Нийлүүлсэн (УБТЗ) Нийгэмлэг, Техникийн бодлого, стандартчиллын албаны харьяа Хэмжил зүйн төв Улаанбаатар хот, Сонгино хайрхан дүүрэг 20-р хороо Харилцах Утас/факс: 247250

Данс: Худалдаа хөгжлийн банк


405101656 "УБТЗ-ын Хэмжил зүйн төв"

Регистрийн дугаар: 9931139

Цахим шуудангийн хаяг: tsm@ubtz.mn

Захиалагч байгууллагыг төлөөлж:

"АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ"
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
М.МӨНХӨӨ



Гүйцэтгэгч байгууллагыг төлөөлж:

"УБТЗ" ХНН-ИЙН ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВИЙН ДАРГА Д.ТҮВШИНБАЯР



"Хэмжих хэрэгсэлд шалгалт баталгаажуулалт хийх" 2023 оны
 тоот гэрээний хавсралт

БАТЛАВ

УБТЗ ХНН-ИЙН ХЭМЖИЛ ЗҮЙН ТӨВИЙН ДАРГА

Д.ТҮВШИНБАЯР

ЗӨВШӨӨРСӨН

"АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ" ТӨХК-ИЙН

СҮҮИЦЛЭХ ЗАХИРАЛ

М.МӨНХӨӨ

ХЭМЖИХ ХЭРЭГСЛИЙГ 2023 ОНД ШАЛГАЛТ БАТАЛГААЖУУЛАЛТАД ХАМРУУЛАХ ГРАФИК

№	Хэмжих хэрэгслийн нэр, загвар, маяг	Хэмжих хязгаар	Наривчлалын анг	Баталгаажуулалт хоорондын хугацаа	Өмнөх баталгаажуулалт хийсэн огноо	Баталгаажуулалт хаана хийлгэх	Баталгаажуулах хугацаа	Тоо ширхэг	Шалгах арга		Баталгаажуулалтын төлбөр, төгрөг			
									Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ		
1	2	3	4	5	6	7	8	9			10	11		
2023 онд баталгаажуулалтад хамрагдах хэмжих хэрэгслийн жагсаалт														
1	Төмөр замын электрон жин, SD-150RW загварын	150 гн	d50 кг	6 сар	2022.09.15	"Амгалан Дулааны станц" ТӨХК	3, 9 саруудад	2	Статик хэмжилт	460000	920000	Эталон тавцант вагон ашиглан шалгах	410000	820000
2023 онд шалгалт баталгаажуулалтад нийт хэмжих хэрэгсэл (ширхэг), нийт төлбөр (төгрөг)											2	1740000		
Лаборатори вагон, Эталон вагоныг тээвэрлэх, таталт тавилгын сэлгээний ажлын зардлыг тухайн өртөөний багтагдсан үнэ тарифаар тооцоно.														